



“МИАТ” ТӨРИЙН ӨМЧИТ  
ХУВЬЦААТ КОМПАНИД

## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.04.11 № 03/2562  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан МИАТ/20240102011 дугаартай “Энгийн ангиллын нэг удаагийн чихэвч” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон “Ач-Үр” ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох материалд үндэслэн гомдлын хүрээнд хянан үзлээ.

“Ач-Үр” ХХК-ийн гомдолд 2023 оны санхүүгийн тайланг цахим системээр ирүүлээгүй, 2021, 2022 оны борлуулалтын орлогын хэмжээ шаардлага хангахгүй гэж тус компанийн тендерээс татгалзсан захиалагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байх тул хянан үзэхийг хүссэн байна.

Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын 2.5.3-т “хуульд заасан эрх бүхий этгээдээс олгосон зөвшөөрөл (энгийн болон тусгай)-ийн мэдээлэл, авто тээврийн хэрэгслийн эзэмшигчийн лавлагаа, дээд боловсролын дипломын мэдээлэл, санхүүгийн тайлан зэрэг бодит цагийн горимоор дамжуулдаг, өдөр тутам өөрчлөгддөггүй мэдээлэл”-ийг захиалагч тендер хянан үзэхэд үндэслэл болгоно гэж заасан.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “...Сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу гаргасан санхүүгийн тайлан /Цахим системээр дамжуулан шалгана/” гэж заасны дагуу “Ач-Үр” ХХК-ийн тендер тухайн хугацааны санхүүгийн тайланг худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр ирүүлсэн байхад 2023 оны санхүүгийн тайлан ирүүлээгүй гэж тус компанийн тендерээс татгалзсан захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

“Ач-Үр” ХХК-ийн 2021, 2022, 2023 оны санхүүгийн тайлангаас үзэхэд тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.1-д “...ТШЗ-ны 19.1-д заасан хугацаанд гүйцэтгэсэн нийт борлуулалтын орлогын хэмжээ нь багц тус бүрд батлагдсан төсвийн 50 хувиас багагүй байх” шаардлагад нийцэж байхад борлуулалтын орлогын хэмжээ шаардлага хангахгүй гэж тус компанийн тендерээс татгалзсан захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

9766004305


Иймд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 1/696 тоот шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж байна.

Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь заалтыг үндэслэн мэдэгдье.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: "Ач-Үр" ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

A handwritten signature in black ink, enclosed within a rectangular dotted border. The signature is stylized and appears to be the name 'Ж. ГАНБАТ'.

Ж.ГАНБАТ